



**"АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨҮГ-ЫН
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2025.02.15

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Үйл ажиллагааны хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан "Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2024 оны үйл ажиллагааг гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Нийтийн мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт зэрэг 5 үзүүлэлтээр үнэлж, нэгдсэн дүнгээр **84.2** хувьтай байна. Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

**2.1. "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2024 оны
гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:**

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын нь 2024 онд 63 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөө батлан ажилласан байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 63 арга хэмжээнээс 100 хувийн биелэлттэй 31 арга хэмжээ, 90 хувийн биелэлттэй 7 арга хэмжээ, 70 хувийн биелэлттэй 12 арга хэмжээ, 50 хувийн биелэлттэй 5 арга хэмжээ, 30 хувийн биелэлттэй 8 арга хэмжээний хэрэгжилт дунджаар **80.3** хувьтай байна. Үнэлгээний задаргааг доорх хүснэгтэд үзүүлэв.

/Хүснэгт 1/

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
63	31	7	12	5	8	-	-	80.3

Төлөвлөгөөнд хэрэгжилт хангалтгүй 30 хувийн 8 арга хэмжээ:

№	Арга хэмжээний заалт, агуулга	Хүрэх түвшин	Ирүүлсэн биелэлт
1	3.3. Дорноговь аймгийн Замын-Үүд, Говьсүмбэр, Говь-Алтай аймагт автобуудлын барилгыг улсын төсөв болон төр хувийн түншлэлийн хүрээнд барих ажлыг эхлүүлэх	Зорилтот түвшин: III-IV улирал: Говь-Алтай аймгийн автобуудлын барилгын ажлыг гүйцэтгэлийг 30%-д хүргэнэ. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын автобуудлын барилгын ажлын гүйцэтгэлийг 20%-д хүргэнэ. Говь-Сүмбэр аймгийн зорчигч тээврийн автобуудлын барилгын ажлыг эхлүүлнэ.	Замын-Үүд: ШУТИС-ийн барилга архитектурын сургуулийн мэргэжилтнүүдэд барилгыг үргэлжлүүлж барихад шаардлагатай хүчитгэлийн дүгнэлтийг хүргүүлсэн. Дорноговь аймгийн Замын-Үүд суманд баригдах автобуудлын барилгын асуудлаар ЭЗХЯ-нд 2024.03.13-ны өдрийн 1/293 тоот албан бичиг хүргүүлсэн. Тус үйлдвэрийн газрын 2024 оны урсгал зардлын төлөвлөгөөнд Замын-Үүд суманд баригдах барилга байгууламжийн холболтын зураг, төсвийг шинэчлэх ажил тусгагдаж, тухайн ажлыг гүйцэтгэхээр шалгарсан "Тэмжин" ХХК-тай гэрээ байгуулсан гүйцэтгэлийн шатандаа явж байна. Говь-Алтай: Говь-алтай аймагт автобуудал, техникийн хяналтын үзлэгийн төвийн барилгыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024-2026 онд нийт 3,2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр барьж байгуулахаар тусгагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны газраас дээр ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа зохион байгуулсан бөгөөд "Мөрөн-Алтай" ХХК шалгарч ЗТХЯ-тай гэрээ байгуулсан. Тус барилгын ажил явагдах газар болон зураг төсөвт өөрчлөлт орсны улмаас барилгын ажил эхлээгүй байна. Зураг төсөвт яаралтай өөрчлөлт оруулан зургийн ажлыг дуусгахаар яаравчлан ажиллаж байна. Говьсүмбэр: Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Говьсүмбэр аймгийн автобуудлын барилгыг барих талаар үйлдвэрийн газраас ТӨБЗГ-т хүсэлт гаргаж, ЗТХЯ-наас дэмжлэг авч, шийдвэрлүүлэхээр хүсэлт хүргүүлсэн. Говьсүмбэр аймгийн автобуудал барилгын ажил эхлээгүй газрын асуудал яригдаж байна 2023.11.08-ны өдөр "Өв хангамж групп" ХХК-тай уулзалт хийж, тус компаниас ТӨБЗГ-т албан бичиг хүргүүлсэн. "Өв хангамж групп" ХХК-аас тус үйлдвэрийн газарт холбогдох тооцоо судалгааг гаргаж, ирүүлээгүй байна.
2	5.3. Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй	Зорилтот түвшин: III-IV улирал:	Цахилгаан автомашин /EV/ цэнэглэх сүлжээг өргөтгөх чиглэлээр: Манай улсын хэмжээнд цахилгаан автомашин/EV/ цэнэглэх 30 цэнэглэх

тээврийн хэрэгслийн цэнэглэх сүлжээг ШТС, үйлчилгээний газруудыг түшиглэн төр хувийн хэвшлийн түншлэлээр байгуулах	Орон нутагт шинээр цахилгаан автомашин цэнэглэх 5 станц, хийгээр ажилладаг автомашин цэнэглэх 3 станц байгуулсан байна.	байгууламж байгаагаас орон нутагт 6, нийслэлийн 24 байршилд цэнэглэх байгууламж байна. "ЛЕАФ ЦЕНТР" ХХК -тай хамтран Орхон, Хөвсгөл, Говьсүмбэр аймгуудын автотээврийн төвийн гадна талбайд 380в-ын тогтмол гүйдлийн түргэн цэнэглэх станц байршуулах талаар хамтран ажиллахаар тохирсон. Энэ хүрээнд 380в-ын тогтмол гүйдлийн түргэн цэнэглэх станцыг компанийн санхүүжилтээр шийдвэрлэх ба байршуулахад шаардлагатай ажлын зардлыг тус үйлдвэрийн газраас гаргах талаар тохирсон. Энэ ажилд 60.0 сая төгрөгний санхүүжилт шаардлагатай ба тус үйлдвэрийн газрын 2025 оны зорилтот түвшинд тусган батлуулахаар санал өгсөн. Мөн цахилгаан автомашин цэнэглэх станцыг байгуулахад шаардлагатай хууль, дүрэм, стандартад нэмэлт өөрчлөлт оруулах талаар дараах ажлыг хийсэн. Үүнд: - Газар ашиглалтын Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн газрын даргын 2023 оны А/112 дугаар тушаалаар баталсан "Газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл хөтлөх журам"-ын 1 дүгээр хавсралтад "Цахилгаанаар цэнэглэх станц"-ын ангилал, код тусгагдаагүй тул АТҮТ-ийн захирлын 1/970 тоот албан бичгээр саналыг тусган хүргүүлж тухайн ангилал, кодыг нэмүүлсэн. - Автозамын дагуух үйлчилгээний цогцолбор, түүний барилга, байгууламжид тавигдах нийтлэг шаардлага MNS 5537:2016 стандартад цахилгаанаар цэнэглэх станцын үйлчилгээг тусгах саналыг АТҮТ-ийн захирлын 1/969 тоот албан бичгээр Тээврийн цагдаагийн алба, Стандарт хэмжилзүйн газар, автозамын дагуу үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн холбоонд хүргүүлсэн. Байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэх сүлжээг өргөтгөх чиглэлээр: Шингэрүүлсэн хий /LPG/-н станцыг орон нутагт шинээр байгуулах, хамтран ажиллах саналыг боловсруулан 2023.03.05-ны өдрийн 1/257 тоот албан бичгээр энэ төрлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй 10 аж ахуйн нэгжид хүргүүлсэн. "Горгаз", "Дашваанжил",
---	--	--

			"Юнигаз" ХХК-уудтай уулзалт ярилцлага хийсэн. Уулзалтаар дараах нийтлэг саналыг ирүүлсэн. - Цахилгаан, эрчим хүчний хүчин чадлын хүрэлцээ хангамж муу тул шинээр ШТС барихад хүндрэл ихтэй. - Байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн тоо жил ирэх тусам багасч, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ буурсаар байна. - Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй цэнэглэх сүлжээний ашигт ажиллагаа муу байдаг гэх мэт нийтлэг хүндрэлүүдийг хэлж байсан. Иймд одоогоор шинээр байгуулах байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэх сүлжээг өргөтгөх хэрэгцээ шаардлага, зах зээл байхгүй талаар дурдаж байсан.
3	7.5. Монгол улс болон Беларус улсын ээлжит уулзалтад оролцож хоёр улсын хооронд хийх тээвэрлэлтийг нэмэгдүүлэх	Зорилтот түвшин: III-IV улирал: Беларус улсад зохион байгуулагдах ээлжит уулзалтад оролцож ачаа тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.	Монгол улс болон Беларус улсын ээлжит уулзалтад оролцож хоёр улсын хооронд хийх тээвэрлэлтийг нэмэгдүүлэх талаар ЗТХЯ-наас чиглэл ирүүлээгүй байна. Уулзалтад оролцох бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. ЗТЯ-наас чиглэл ирүүлээгүй байна.
4	7.6. Монгол улс болон Иран, Пакистан, Герман, Словак, Болгар, Гүрж, Узбекистан улстай автотээврийн хэлэлцээр байгуулах	Зорилтот түвшин: III-IV улирал: Уулзалтад оролцож авто тээврийн хэлэлцээрийг байгуулсан байна.	Монгол улс болон Иран, Пакистан, Герман, Словак, Болгар, Гүрж, Узбекистан улстай автотээврийн хэлэлцээр байгуулах талаар ЗТХЯ-наас чиглэл ирүүлээгүй байна. Уулзалтад оролцох бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. ЗТЯ-наас чиглэл ирүүлээгүй байна.
5	7.7. Монгол улс болон ОХУ, Польш, Литва улсын уулзалтын хуралд оролцож монгол тээвэрлэгч тээвэрлэлт хийх боломжийг нэмэгдүүлэх	Зорилтот түвшин: III-IV улирал: Уулзалтад оролцож ОХУ, Польш, Литва улсад манай улсын тээвэрлэгчид тээвэрлэлт хийх	Монгол улс болон ОХУ, Польш, Литва улсын уулзалтын хуралд оролцож монгол тээвэрлэгч тээвэрлэлт хийх боломжийг нэмэгдүүлэх талаар ЗТЯ-наас чиглэл ирүүлээгүй байна.

		нөхцөл боломж нэмэгдсэн байна.	
6	8.4. Улс хоорондын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээнд суудлаар даатгалд хамруулах хувилбарыг судалж, хэрэгжүүлэх	Зорилтот түвшин: III-IV улирал: Улс хоорондын зорчигч тээврийн хэрэгслээр зорчиж буй зорчигчдыг 100% даатгалд хамруулсан байна.	Гадаад орноос Монгол улс руу нийтийн зорчигч тээврийн хэрэгслээр зорчиж буй зорчигчдын мэдээлэл манай бүртгэлийн системд бүртгэгддэггүй учир зорчигчид ямар нэгэн даатгалд хамрагдахгүй, аливаа эрсдэлийн үед даатгалын нөхөн олговор авч чадахгүй хохирох тохиолдлууд бүртгэгдэж байсан. Дараах шат дараалсан арга хэмжээг авч ажилласан. Үүнд: • Зорчигчдыг хэрхэн суудлаар даатгалд хамруулах талаар санал хүсэлтээ ирүүлэхийг Улс хоорондын чиглэлд нийтийн зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэгч ААНБ-уудад 2024.01.29-ний өдрийн 1/93 албан тоотоор хүргүүлсэн. • Улс хоорондын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэгч ААНБ- уудтай 2024.06.25-ны өдөр zoom-ээр онлайн уулзалт зохион байгуулж, боломжит хувилбар, бодит байдлын судалгааг нэгтгэн гаргасан. • Даатгалын үйл ажиллагаа эрхлэгч ААНБ-уудад 2024.10.16-ны өдрийн 1/1119 албан тоотыг хүргүүлэн, даатгалын нөхөн олговрын судалгааг нэгтгэн гаргасан. Улс хоорондын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэгч ААНБ-ууд нь дурын даатгалын байгууллагатай гэрээ байгуулан, зорчигчдыг даатгалд хамруулан, даатгалын нөхөн олговор олгохыг 2024.11.14-ний өдрийн 1/1271 албан тоотоор мэдэгдсэн.
7	8.8. Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн сургалт шалгалтын нэгдсэн санг Цагдаагийн ерөнхий газрын жолоочийн зам тээврийн осол, зөрчлийн сантай холбох	Зорилтот түвшин: I-IV улирал: Мэргэшсэн жолоочийн сургалт шалгалтын нэгдсэн сан, Цагдаагийн ерөнхий газрын жолоочийн зам тээврийн осол, зөрчлийн сантай холбогдсон байна.	Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн сургалт шалгалтын нэгдсэн санг Цагдаагийн ерөнхий газрын жолоочийн зам тээврийн осол, зөрчлийн сантай холбох ажлын хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба, Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанд мэдээлэл солилцон хамтран ажиллах, жолоочийн зам тээврийн осол, зөрчлийн сантай холбох талаар 2024.03.05-ны өдрийн 1/265 албан тоот бичиг хүргүүлсэн. Тус албанаас 2024.04.24-ний өдрийн 15/1400 тоотоор зам, тээврийн осол, зөрчилд холбогдсон иргэний талаарх мэдээллийг холбогдох эрх зүйн баримт бичигт тусгаж, батлуулсан тохиолдолд мэдээллийг харилцан солилцож ажиллах боломжтой талаар хариу ирүүлсэн.

			Зам, тээврийн яамнаас Мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох журмыг шинэчлэн батлуулахаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа бөгөөд тус журамд зам тээврийн осол, зөрчилд холбогдсон иргэний мэдээллийг "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-тай солилцдог байх талаар журмын төсөлд санал оруулахаар бэлтгээд байгаа бөгөөд ажлын хэсэг 2023.06.15-ны өдрөөс хойш дахин хуралдаагүй байна.
8	9.4. Такси үйлчилгээ. Ерөнхий шаардлага. MNS 5122:2013, Жуулчны автотээврийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5231:2003, Улс хоорондын автотээврийн ачаа, зорчигч тээвэрлэлт. Тээвэрлэлтийн ерөнхий шаардлага MNS 5831:2007 стандартыг шинэчлэн батлуулах	Зорилтот түвшин: III-IV улирал: Хэлэлцүүлэг зохион байгуулан 3 стандартын төслийг Автотээврийн стандартчиллын техникийн хороогоор хэлэлцүүлж дэмжигдсэн байна.	1. Жуулчны автотээврийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5231:2003 стандартыг шинэчлэх төслийг боловсруулж, ЗТХЯ-нд 2024.05.01-ний өдрийн 1/518 тоот албан бичгээр хүргүүлсэн. 2. Такси үйлчилгээ. Ерөнхий шаардлага. MNS 5122:2013 стандартыг шинэчлэх төсөлд санал авах тухай 2024.11.29-ний 1/1320 тоот албан бичгийг хот хоорондын такси тээврийн үйлчилгээний 7 аж ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлж саналыг нэгтгэн ажиллаж байна. 3. Улс хоорондын автотээврийн ачаа, зорчигч тээвэрлэлт. Тээвэрлэлтийн ерөнхий шаардлага MNS 5831:2007 стандартыг шинэчлэх төсөлд санал авах тухай 2024.12.02-ний 1/1334 тоот албан бичгийг улс хоорондын тээвэрлэлт гүйцэтгэж буй аж ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлж саналыг нэгтгэн ажиллаж байна.

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

2024 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавраар өгөгдсөн 15 заалтыг тус газар хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнээс бүрэн хэрэгжсэн 9, хэрэгжих шатанд буюу 70 хувийн хэрэгжилттэй 6 арга хэмжээний дундаж үнэлгээ 88.0 хувьтай байна. Хэрэгжилтийн үнэлгээг авч үзвэл:

/Хүснэгт 3/

№	Үүрэг даалгаврын нэр	Арга хэмжээ тоо	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хучингүй болсон	Хэрэгжилт хувь
1	МУ-ын хууль ЗГ-т	1	1		-	-	-	-	100.0

2	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	1	-	1	-	-	-	-	70.0
3	УИХ-ын тогтоол	1	-	1	-	-	-	-	70.0
4	Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж	1	1	-	-	-	-	-	100.0
5	Засгийн газрын тогтоол	3	-	3	-	-	-	-	70.0
6	Засгийн газрын албан даалгавар	1	1	-	-	-	-	-	100.0
7	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	7	6	1	-	-	-	-	95.7
Нийт		15	9	6	-	-	-	-	88.0

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрт 70 хувьтай хэрэгжилт 6 арга хэмжээ байна. Үүнд:

(Хүснэгт 4/

№	Эрх зүйн актын нэр, агуулга, огноо, дугаар	Заалт
УИХ-ын Байнгын хорооны тогтоол		
1	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021-12-28 Дугаар 2021 №06 УББХ	1.1... нүүрсний экспортыг нэмэгдүүлэхтэй холбоотой хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадал, тээвэрлэлтийг нэмэгдүүлэх төслүүд (чингэлэгт тээврийн терминал, жолоочгүй тээврийн хэрэгсэл, дүүжин тээвэр, конвейерийн систем);
УИХ-ын тогтоол		
2	Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2023-01-12 Дугаар 2023 №06	1.2... биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг баталж, шаардлагатай дэд бүтэц /итгэмжлэгдсэн лаборатори, агуулах, терминал, тээвэр логикийн төв/-ийг бий болгох;
Засгийн газрын тогтоол		
3	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_204	6. Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автомашинд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар олгох арга хэмжээг 2022 онд багтаан зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт даалгасугай.
4	Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2023-06-21 Дугаар 2023_233	8. Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулахад радио давтамжаар таних систем (RFID)-ийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ашиглалтад оруулахыг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт даалгасугай.
5	Ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цаг, үйлчилгээний цогцолбор барьж байгуулах тухай	4.6. 6.Олон улс, улсын чанартай авто зам дагуу ариун цэврийн байгууламж бүхий үйлчилгээний цогцолбор барих, түр буудаллах цаг байгуулахад шаардлагатай дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд

	2024-05-01 Дугаар 2024_189	С.Бямбацогт, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн нарт даалгасугай
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл		
6	2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 18 дугаар тэмдэглэл 2023-04-26 Дугаар 2023_18	XIV.1.2. "Зам тээврийн ухаалаг систем RFID" төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт.

2.3. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

2024 оны жилийн эцсийн байдлаар Сайдын тушаалаар тус газарт 21 үүрэг даалгавар өгөгдсөн байна. Үүнээс бүрэн хэрэгжсэн 14, 70 хувийн 5, 30 хувийн 2 арга хэмжээний дундаж үнэлгээ 86.2 хувь байна. Хэрэгжилтийг үнэлгээг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 5/

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
21	14	5	2	-	-	-	86.2

Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгавраар 30 хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээ байна. Үүнд:

/Хүснэгт 6/

№	Үүрэг даалгавар	Биелэлт
Нийтийн тээврийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2024.01.25 №А/23		
1	1.2. Стандартын түдгэлзүүлсэн заалтад хамаарах автобусны техникийн хяналтын үзлэгийг зөвхөн суурин төвд, камерын хяналт дор зохион байгуулж, дүрс бичлэгийг баримтжуулж хадгалах	Хот хоорондын нийтийн тээврийн автобуснуудыг суурин үзлэгийн төвөөр камерын хяналтын дор техникийн хяналтын үзлэгт хамруулж байна.
2	1.4. Ашиглалтын хугацаа сунгасан автобусны техникийн үйлчилгээг цаг тухайд нь тогтмол гүйцэтгэхэд байнгын хяналт тавих;	Аж ахуйн нэгж байгууллагуудад 2024.02.20-ны өдөр 1/174 тоот албан бичгийг хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

2.4. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох" журмыг үндэслэн шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийн агуулга, стандартын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллаж байна.

Шилэн дансны цахим хуудсанд заавал байршуулах 28 мэдээллээс бүрэн байршуулсан 17, хугацаа болоогүй 10, буруу мэдээ байршуулсан 1 арга хэмжээний дундаж хэрэгжилт **94.4** хувьтай байна.

/Хүснэгт 7/

Мэдээлэл		Нийт заалт	Үүнээс					Биелэлт хувь
			100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
АТҮТ "ТӨҮГ"	төсөв, гүйцэтгэл	14	6	-	-	1	7	85.7
	хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	6	4	-	-	-	2	100.0
	бусад	8	7	-	-	-	1	100.0
Нийт		28	17	-	-	1	10	94.4

Хэрэгжилт тасарсан 0 хувийн 1 арга хэмжээ байна. Үүнд:

/Хүснэгт 8/

№	Хэсэг	Тайлангийн нэр	Тайлбар
1	Төсөв, гүйцэтгэл	Санхүүгийн тайлан	2023 оны Санхүүгийн тайлангийн оронд аудитын дүгнэлтийг тайлагнасан.

2.5. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ:

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам"-ын 9 дүгээр хавсралтад заасан мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийн дагуу 5 хэсгийн 46 арга хэмжээний хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар **83.1** хувь байна. Шалгуур үзүүлэлт тус бүрийн үнэлгээг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 9/

Хэсэг	Нийт Арга хэмжээ	Үнэлгээ /хувиар/					Чиг үүрэгт хамаарахгүй	ХШҮ
		100	70	30	0	Хугацаа болоогүй		
1	10	3	3	1	1	-	2	67.5
2	6	4	1	1	-	-	-	83.3
3	15	11	-	1	1	-	2	86.9
4	2	-	1	-	-	-	1	70.0
5	13	6	1	-	-	-	6	95.7
Нийт	46	24	6	3	2	-	11	83.1

Мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд 0-30 хувийн 5 арга хэмжээ байна. Үүнд:

/Хүснэгт 10/

№	Арга хэмжээний	Шалгуур үзүүлэлт	Санал, зөвлөмж
---	----------------	------------------	----------------

дугаар			
"0" хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээ			
1	1.10.	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр	Мэдээлэл хариуцагчаас тухайн жил зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр батлуулж, сайтаар мэдээлж байх
2	3.3.	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг оруулаагүй тул хуулийн хугацаанд мэдээлж байх
"30" хувийн хэрэгжилттэй 3 арга хэмжээ			
3	2.5.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай бүр мэдээлэх, мэдээллийг баяжуулах
4	1.9.	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл	Сар, улирал, жилээр мэдээлэл тайлан гарч байгаа, статистик мэдээллийг байршуулаагүй тул тухай бүр байршуулж байх
5	3.10.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан	Шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааны тухай мэдээлэл байхгүй, өөрийн байгууллагын сайтаар мэдээлж байх

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

3.1. "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахдаа ХШҮДАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу арга хэмжээнүүдийг хариуцах хэлтэс, албадыг нэр заан тусгаж, яамтай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний хүрэх түвшин, оролцох үүрэг, хариуцлагыг ялгаатай тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрэх түвшнийг улирлаар хуваан яамны төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн байна.

3.2. "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2024 оны үйл ажиллагааг гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Нийтийн мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт зэрэг 5 үйл ажиллагааны нийт 173 арга хэмжээний хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

3.3. "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2024 оны үйл ажиллагаанд нийт 173 арга хэмжээг хяналтад авч үүнээс бүрэн хэрэгжсэн буюу 100 хувийн хэрэгжилттэй 95, 90 хувийн хэрэгжилттэй 7, 70 хувийн хэрэгжилттэй 29, 50 хувийн хэрэгжилттэй 5, 30 хувийн хэрэгжилттэй 13, тасарсан буюу 0 хувийн хэрэгжилттэй 3, хугацаа болоогүй 10, үнэлгээнд тооцогдохгүй буюу чиг үүрэгт хамааралгүй 11 арга хэмжээний дундаж үнэлгээ 84.2 хувьтай дүгнэгдсэн байна.

3.4. 2024 онд Улс, хот хооронд 2.4 сая зорчигч тээвэрлэхээр төлөвлөсөн ба жилийн эцсийн байдлаар 1,9 сая зорчигч тээвэрлэсэн нь үзүүлэлттэй байна. Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж, 9 боомтын 47 уурхайгаас 82,8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 23 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Дөрөв. Санал, зөвлөмж:

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2024 оны үйл ажиллагаанд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах санал зөвлөмжийг хүргүүлж байна.

4.1. Олон улс, улсын чанартай авто замын дагуу 150-200 км тутамд үйлчилгээний цогцолбор байгуулах, Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэх сүлжээг шатахуун түгээх станц болон үйлчилгээний газруудыг түшиглэн төр хувийн хэвшлийн түншлэлээр байгуулах, Замын-Үүд, Сэлэнгэ, Булган, Говьсүмбэр, Дорнод, Сүхбаатар, Дундговь, Өвөрхангай, Ховд, Говь-Алтай зэрэг аймгийн төвд зорчигч тээврийн автобуудал байгуулах зэрэг бодлогын баримт бичигт туссан арга хэмжээг эрчимжүүлэх;

4.2. Монгол улс болон Беларус улсын ээлжит уулзалтад оролцож хоёр улсын хооронд хийх тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, болон Иран, Пакистан, Герман, Словак, Болгар, Гүрж, Узбекистан улстай автотээврийн хэлэлцээр байгуулах, ОХУ, Польш, Литва улсын уулзалтын хуралд оролцож монгол тээвэрлэгч тээвэрлэлт хийх боломжийг нэмэгдүүлэх арга хэмжээ зорилтот түвшинд хүрээгүй, хариуцах чиг үүрэг тодорхой бус, төлөвлөлтийн алдаатай байгааг анхаарч ажиллах;

4.3. "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой дараах ажлуудыг хийж гүйцэтгэх шаардлагатай байна. Үүнд: Хүний нөөцийн стратеги хөтөлбөр, түүнийг үнэлэх журам, Улс хоорондын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээнд суудлаар даатгалд хамруулах хувилбарыг судалж, хэрэгжүүлэх, Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн сургалт шалгалтын нэгдсэн санг Цагдаагийн ерөнхий газрын жолоочийн зам тээврийн осол, зөрчлийн сантай холбох, шинэ чиглэлүүд эхлүүлэх, илгээмжийн ачааг хүлээн авах, бүртгэлжүүлэх, хадгалах, тээвэрлэх, хүлээлгэн өгөх үйлчилгээг өргөжүүлэх зэрэг арга хэмжээг эрчимжүүлэх;

4.4. Такси үйлчилгээ. Ерөнхий шаардлага. MNS 5122:2013, Жуулчны автотээврийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5231:2003, Улс хоорондын

автотээврийн ачаа, зорчигч тээвэрлэлт. Тээвэрлэлтийн ерөнхий шаардлага MNS 5831:2007 стандартыг шинэчлэн батлуулах болон дүрэм, журам стандартын хэрэгжилтийг хангуулах зэрэг зохион байгуулалтын ажлыг бүрэн хэрэгжүүлэх;

4.5. Зам, тээврийн хөгжлийн сайдын "Нийтийн тээврийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" 2024 оны А/23 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах;

4.6. Мөн "Мэдээлэл хариуцагч нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хангахад Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, нийтэд нээлттэй ил тод байх мэдээллийг байнгын шинэчлэн, хуулийн хэрэгжилтийг тухай бүр бүрэн хангуулахад анхаарч ажиллахыг тус тус зөвлөж байна.

ТАНИЛЦСАН:

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

С.БАТБОЛД

АТБЗГ-ЫН ДАРГА

Э.МӨНХНАСАН

"АТУТ" ТӨҮГ-ЫН
ЗАХИРАЛ

Б.ГҮРСОРОНЗОН

ХЯНАСАН:

ХШУДАГ-ЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ОЮУНТУЯА

БОЛОВСРУУЛСАН:

ХШУДАГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Э.СОЛОНГО



**“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ-ЫН 2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
НЭГДСЭН ДҮН**

/2024 оны IV улирлын байдлаар/

№	Хяналтад авсан арга хэмжээний нэр	Нийт арга хэмжээ	Үнэлгээ /хувиар/							Үнэлгээнд тооцогдохгүй арга хэмжээ	
			Дундаж хувь	100	90	70	50	30	0	Хугацаа болоогүй	Хамаарал гүй
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	63	80.3	31	7	12	5	8	-	-	-
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	15	88.0	9	-	6	-	-	-	-	-
3	Сайдын тушаалын биелэлт	21	86.2	14	-	5	-	2	-	-	-
4	Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	28	94.4	17	-	-	-	-	1	10	-
5	Мэдээллийн ил тод байдал	46	83.1	24	-	6	-	3	2	-	11
Нийт		173	84.2	95	7	29	5	13	3	10	11



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ-ЫН 2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮНГ ГРАФИКААР ҮЗҮҮЛБЭЛ:

